

# ТӨРӨӨС ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ҮЗҮҮЛЖ БАЙГАА ДЭД БҮТЦИЙН СУДАЛГАА

*Б. Нандинболор  
Магистрант*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн ахисан түвшний сургууль*

*nandinbolor931101@gmail.com*

**Хураангуй:** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанар, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах үндсэн нөхцөл нь нийгмийн орчин, биет хүрээлэн орчны нөхцөлийг сайжруулах нь хүний эрхийг хэрэгжүүлж, дээдэлж буй нлэрхийлэл юм. Монгол улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо жилээс жилд өсч байгаа нь эдгээр иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг суурь шалтгаан, үндэслэлтэйгээр судлах хэрэгцээ тулгамдаж эхэлж байна. Иймд эдгээр бүлгийн иргэдэд үзүүлж буй өнөөгийн нийгмийн үйлчилгээ, хүрээлэн буй дэд бүтцийн талаарх судалгааг хийж, цаашид асуудлыг шийдэх оролцогч талуудад магистрынхаа судалгаа шинжилгээний ажлын үр дүнгээс хуваалцаж, өөрийн санал, зөвлөмжийг дэвшүүлэхийг зорилоо.

**Түлхүүр үгс:** Хөгжлийн бэрхшээл, дэд бүтэц, иргэний нийгэм, төрийн бодлого

## УДИРТГАЛ

Монголд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандаж буй хандлага, эдгээр хүмүүст хүндэтгэлтэй хандах, дэмжих, туслах сэдлийг төрүүлэх нь бидний ардчилсан хүмүүнлэг нийгмийн нэгэн үзүүлэлт юм. Нэгдсэн үндэсний байгууллагаас 2006 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хэлэлцүүлгийг баталснаар дэлхий дээр амьдарч буй 650 гаруй сая хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн нийгмийн амьдралын бүхий л хүрээнд баталгаатай амьдрах үндсэн суурийг тавьсан юм. Одоогоор 145 орон гарын үзэг зурж, 85 улс орон соёрхон баталж байгаа уг конвенценд Монгол Улс 2009 оны 5 дугаар сарын 13 ний өдөр

нэгдэн орсон бөгөөд 56 дахь улсаар бүртгэгдсэн.[2] Конвенцийн дагуу төрийн зүгээс Монгол улсад амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрийн оролцоог хүлээн зөвшөөрч нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцуулж сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх гээд хүний хийх ёстой бүхий л эрхийн хангаж буй орчинд амьдарч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд нийгмийн амьдралын бүхий л хүрээнд алагчлагдах бусадтай харьцуулахад тэгш бус боломжтой байх зэргээр эрх нь зөрчигдсөөр байгаа тул хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци батлуулах явцад нэгдсэн ойлголтод хүрч чадсан. Тэрхүү ойлголц нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүний

эрхийн тухай конвенци”- д тусгалаа олжээ.

Уг конвенцид “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэг бол бие махбод, оюун санааны, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээд гэж тодорхойлсон байдаг.[2]

Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай Монгол улсын хуулийн 1 дэх зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж тодорхойлжээ.[9]

Хөгжлийн бэрхшээлийн ангилал:

- ❖ Харааны
- ❖ Сонсголын
- ❖ Хэл, ярианы
- ❖ Хөдөлгөөний
- ❖ Сэтгэцийн
- ❖ Бусад

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд орчны саад бэрхшээлээс шалтгаалан бусдаас байнга дэмжлэг авч, тэднээс хараат, нийгмийн идэвхгүй нэгэн болж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орчны дэд бүтцийн асуудал шийдвэрлэгдэхгүй байгаатай холбоотой ажээ. Хуучин барилгуудаа засварлах боломжгүй

юм гэхэд шинээр баригдаж буй худалдаа үйлчилгээний төв, төрийн байгууллагуудад тэргэнцэртэй болон таягтай хүмүүст зориулсан дэд бүтцийг хийж заншвал хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ихээхэн дөхөм болно гэж иргэд үздэг. Тиймээс цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгмийн харилцаанд оролцох эрхийг хэрэгжүүлэх чиглэлд төрийн байгууллагууд хамтран ажиллахаар болсон байна. Мөн төр, хувийн хэвшлийн байгууллагуудыг тусгайлсан дэд бүтцийг бий болгох чиглэлээр хамтран ажиллах уриалга гаргасан байна.

Монголд өнөөдөр 108071 хөгжлийн бэрхшээлтэй иргэд амьдарч байгаас, нийслэл Улаанбаатар хотод 67069 ХБИ бүртгэлтэй байна. Эдгээр иргэд жирийн иргэдийн адил нийгмийн үйлчилгээг авч чадахгүй байгаа ба үйлчилгээ авч чадахгүй байгаа нэг гол шалтгаан нь ХБИ-д зориулсан дэд бүтэц байхгүй, төр захиргаа олон нийтийн үзвэр үйлчилгээний газрууд тэдний асуудлыг орхидуулсаны улмаас хязгаарлагдмал нөхцөл байдалд амьдрахаас өөр аргагүй байдал үүсээд байна. Иймд эдгээр асуудал нь миний судалгааны ажлыг хийх үндэслэл болж өнөөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхцөл байдалд шинжилгээ хийж, тодорхой цаг хугацааны ахиц, дахин сайжруулах тал дээр ажиллах боломжийн талаар авч үзэх болно.

## ОНОЛЫН ХЭСЭГ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлчилгээний талаарх гадаад орны туршлагаас хуваалцъя.

Япон улсын туршлага: Япон улсын нийслэл болох Токио хот нь нийт 12,908,856 хүн амтай ба нийт иргэдийн 6% буюу 774,532 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Хүйсийн харьцааны хувьд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 56% нь эрэгтэй 44% нь эмэгтэй хүмүүс байна. Хөдөлмөрлөх чадваргүй хүмүүс нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэхдээ бие эрхтэн, сэтгэцийн хүндрэлтэй, оюун ухааны хомстолтой, хөгжлийн бэрхшээлтэй гэж 4 ангилж ялгавартай ханддаг.[1] Бие эрхтний хүндрэлтэй ХБ-тэй иргэд нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх хувийг эзлэх бөгөөд тэдэнд үзүүлэх үйлчилгээг нийгэм хамт олонд түшиглэсэн мэргэжлийн байгууллагын төрөлжсөн гэж ангилдаг.[4] Төрөлжсөн байгууллагын үйлчилгээ : хараа, сонсгол, оюун ухаан, хөдлөх эрхтний хүндрэлийг багасгах сэргээн засах үйлчилгээг мэргэжлийн төвшинд төрөлжсөн үйлчилгээний байгууллагаар дамжуулан үзүүлэх нь ХБ-тэй хүмүүсийн халамжийн үйлчилгээний нэг хэсэг болдог. Төрөлжсөн байгууллагын үйлчилгээнд хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүсийн онцлог нь тохирсон ажил хийлгэх, ярилцлага,

семинарт, оруулах ажлын арга барил эзэмшүүлэх, түр хугацааны хөдөлмөр эрхлүүлэх зэрэг ажил хийдэг.

Дэлхийн хөгжилтэй ихэнх орнууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ тээвэрлэлтэд ихээхэн анхаардаг нь судалгаанаас харагдаж байна. Шатгүй автобус болон лифттэй автобуснаас гадна автобусны буудлыг өндөрчилж өгдөг байна. Дэлхийн томоохон улсуудын хувьд нийт нийтийн зорчигч тээврийн хэрэгслийн 20-30% нь заавал хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан автобус байх шаардлагатай гэсэн хуулийн заалт байдаг байна.[3] Үүнээс гадна автобусны буудлыг өндөрчилж өгөхдөө заавал буудал бүрийг тохижуулах бус нэг юм уу хоёр буудал алгассан зохион байгуулалтай байдаг.

*Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтийн тээврээр үйлчлүүлж байгаа байдал:*



Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтийн тээврээр үйлчлүүлж байгаа байдал:



Улаанбаатар хотын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны ажлын үр дүн

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### Судалгаа ажлын зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж байгаа дэд бүтцийн үйлчилгээний өнөөгийн байдлыг судалж, түүнийг сайжруулах зөвлөмж дэвшүүлэхэд судалгааны ажлын зорилго оршино.

Судалгаанд Улаанбаатар хотын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 100 иргэн хамрагдсан болно. Уг судалгаанд Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн сэргээн засах эмнэлэг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, Мэргэжил сургалт үйлдвэрлэл төвийн ангийн тогооч, талх нарийн боов, компьютер дизайн, оёдол, мужааны оюутнууд хамрагдсан юм.


Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бэрхшээлийн төрлөөр нь авч үзвэл:

Бэрхшээлийн төрөл	Бэрхшээлтэй хүний тоо
Харааны	23
Сонсголын	14
Хэл ярианы	18
Хөдөлгөөний	16
Сэтгэцийн	14
Бусад	15

Эдгээр тоон үзүүлэлтээс харахад манай Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь авч үзвэл харааны 23 хувь, сонсголын 14

хувь, хэл ярианы 18 хувь, хөдөлгөөний 16 хувь, сэтгэцийн 14 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

Зураг 1



Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 53% нь төрөлхийн 47% нь олдмол шалтгаантай байна.

Зураг 2. Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлийн шалтгаан



Судалгаанд хамрагдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 53% нь эрэгтэй 49% нь эмэгтэй нь байна.

Хүснэгт 2. ХБИ-ын өдөр тутам үйлчлүүлдэг байгууллагууд

№	Дараах үйлчилгээний байгууллагуудын аль хамгийн түрүүнд ХБИ- дэд зориулсан дэд бүтцийг байгуулах шаардлагатай вэ?	Тоо
1	Дүүргийн хөдөлмөр халамжийн хэлтэс	18
2	Хороод	16
3	Дүүргийн ЭДТГ	9
4	Эмнэлгүүд	7
5	Банк	5
6	Нийтийн тээврийн автобус	13
7	Нийтийн зам талбай	12
8	Үзвэр үйлчилгээний газар	7
9	Ууш хоолны газрууд	3
10	Хүнс барааны дэлгүүр	5
11	Сургуулиуд	3
12	Бусад	2

Зураг 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлчлүүдэг газрууд



### Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орчин үйлчилгээний судалгаа

Манай улсад 2010 оны байдлаар клинекийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг 1063, өрхийн эмнэлэг 228, эмийн сан 741 байдаг байна. 2010 оны байдлаар 1003 зочид буудал үйл ажиллагаагаа явуулж байгаа мэдээлэл байна. Мөн 2010 оны байдлаар ерөнхий боловсролын 524 сургууль байна. Дээрх асуулгын судалгаанд үндэслэн ХБИ-дэд зориулсан дэд бүтцийн өнөөгийн судалгаанд хийсэн уг судалгаанд төрийн болон төрийн бус хувийн хэвшлийн үйлчилгээний байгууллагууд ХБИ-дэд зориулсан дэд бүтцийн үйлчилгээг ханган хэрэгжүүлж ажиллаж байгааг хангаж чадаж байна уу гэдгийг асуудлыг судлахыг зорьсон.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн зориулалтын дагуу байгуулах шаардлагатай байгаа байгууллагуудад Дүүргийн ХХҮХэлтэсүүд, Хороод, Дүүргийн ЗДТГ, зочид буудлууд, эмийн сангууд, үзвэр үйлчилгээний газрууд, ууш хоолны газрууд,


сургуулиуд эдгээр газруудад орц гарц, лифт, ханын бариул, хөтөвч хаван ариун цэврийн өрөө, гүйдэг хаалга эдгээр зүйлүүд дутмаг муу байгаа нь хүндрэлтэй байна.

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЗОРИУЛСАН БАРИЛГЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН СТАНДАРТ

БД 31-101-83 ХБИ –ийн нийгэмд бие даан амьдрахад нөлөөлөх нэг чухал хүчин зүйл нь орчны саад тотгорыг арилгах явдал юм. Барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан дэд бүтцийг бий болгох явган хүний зам, саадыг багасгах, протез ортопедийн хэрэгслээр хангах, харааны бэрхшээлтэй хүнд зориулж брайл ном сурах бичгээр хэвлэх том үсгээр бичих дохионы орчуулгатай болгох гэх мэт аргуудаар хүртээмжийг бий болгож болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагад 78% нь харьяалалтай 22% нь ямар нэгэн байгууллагад харьяагүй байна.[5]

Нийтийн тээврийн үйлчилгээний ажилтнуудын ХБИ-д хандах хандлага гэсэн асуултад 15% нь сайн 54% нь дунд 18% нь муу 13% нь мэдэхгүй гэсэн байна.



Өвчлөл гэмтлийн шалтгаан нь авто ослоор 40% нь, үйлдвэрлэлийн ослоор 22,8%, ахуйн ослоор мөн 22,8% ба төрөлхийн 3,8%, өвчний улмаас 1,9% гэсэн үзүүлэлттэй гарсан байна. Үүнээс үзэхэд авто ослоор гэмтэгчдийн тоо харьцангуй өндөр байгаа сүүлийн үед энэ төрлийн осол нэмэгдэх болсны жишээ бөгөөд хүмүүс төрөл бүрийн осол гэмтлийн золиос болсоор байна.

Зураг 5. Өвчлөл гэмтлийн шалтгаан



Нийгмийн харилцаанд тэгш эрхтэй оролцоход юу саад болж буй талаарх асуултад 2,36% нь өөрөө сонирхолгүй, 27,6% нь нийгмийн харилцаа, 80,0% нь зам шат хаалга, 98,0% нь унаа гэсэн хариултыг өгчээ. Нийтийн тээврийн аль

төрлөөр зорчдог талаар асуухад автобусаар 8,5%, микроавтобусаар 0,0%, 75% таксигаар, 46,6 нь бусдын унаагаар, 7,6 хувь нь өөрийн унаагаар зорчдог гэжээ.

Зураг 7



Үүнээс үзэхэд нийтийн автобус, микро автобусаар зорчих боломж хомс, голчлон такси болон бусдыг гуйж явдаг байна.

Дээрх тоон судалгааны дагуу зарим нэг асуудлыг тодруулах зорилгоор чанарын судалгаа хийж үзсэн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд гол тулгамдаж буй асуудлыг дараах байдлаар илэрхийлж байна.

#### Кейс: 1

*Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ярилцлага: Сүхбаатар дүүргийн 11-р хорооны иргэн С.Урнаа гадаа гараад явахад зам муу байдаг. Налуу зориулалтын зам байхгүй машины зогсоол байна хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зогсоол ховор байдаг. Машины зогсоолын тэмдэглэл бараг байдаггүй байршуулаад буух зай байдаггүй. Ямар нэгэн байгууллага руу ороход налуу зам байдаг боловч стандарт хангаагүй яаж хүн түрж бууж гарч чадахааргүй хүний нүд хуурсан юм байдаг. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхээр лифт байхгүй нэг давхарт эмчилгээ хийлгэж байгаад плад руу дээшээ ороход жижүүр хүмүүсийг гуйдаг зарим нь уурлаж их бухимдаг.*

Баянгол дүүргийн 7-р хорооны иргэн Бат-Эрдэнэ

## Кейс: 2

*Автобусанд орж чадахгүй налуу зам байдаггүй. Харааны бэрхшээлтэй хүмүүсийг дуудах дуут дохио Монголд хоёрхон байдаг, 100 айлын 129-р сургуульд байгаа. Такси авч явах дургүй зам дээр самбар болон олон юм тавьсан байдаг. Үзвэр үйлчилгээний газруудад үйлчлүүлэхэд хүндрэлтэй. Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөгжиж чадахгүй байгаа нь төрөөс баримталж байгаа бодлого нь хэрэгждэггүй зөвхөн чуулган дээр л яригдаад өнгөрдөг болсон. Сүүлийн үед оюуны бэрхшээлтэй хүүхдүүд их нэмэгдэж байгаа үүний шалтгааныг бас олох хэрэгтэй гадаад дотоод орчны.*

### ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Дээрх судалгаанаас үзэхэд төрийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийг байгуулах шаардлагатай байна. Сүүлийн үед баригдаж байгаа барилга үйлчилгээний байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг шийдэж ажиллаж байгаа нь сайшаалтай. ХБИ- дэд нийтлэг тохиолдог хамгийн гол бэрхшээл нь тэдэнд зориулсан зориулалтын дэд бүтэц байхгүй явдал юм. Нийтийн зам талбай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих наад захын хэрэгцээ стандартыг хангагдаагүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтийн тээврийн хэрэгслүүдээр үйлчлүүлэх шат довжоо, нь хэт өндөр зогсоол буудлын хашлага, довжоо нь зориулалтын биш учраас маш их хүндрэлтэй байдаг. Дэд бүтцийн хөгжил муу байгаа нь харааны бэрхшээлтэй иргэдэд хөгжлийн бэрхшээлтэй бусад төрлүүдтэй харьцуулахад илүү айдастай бөгөөд хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг байна. Хөгжлийн

бэрхшээлтэй иргэн нийтийн тээврээр үйлчлүүлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ялган гадуурхдаг. ХБИ-н дэд бүтцийн асуудлыг холбогдох төрийн байгууллагад шийдвэрлэж өгөх ёстой гэж судалгаанд оролцсон ХБИ үзэж байна. Мөн ХБИ-ийн чиглэлээр явуулдаг төрийн бус байгууллагууд идэвхтэй үйл ажиллагааг явуулж төр засгийн байгууллагуудад ХБИ-ийн дэд бүтцийн бүрдүүлэхэд шахалт үзүүлэх хэрэгтэй гэж судалгаанд оролцогчид үзэж байна. Энэ тэргүүнд нийтийн зам талбай болон ХБИ-ийн байнгын үйлчилгээ авдаг төрийн байгууллагууд болох дүүргийн хөдөлмөр халамж хэлтэс, эрүүл мэндийн нэгдэл, хороо болон дүүргийн засаг даргын тамгын газар гэх мэт улсын байгууллагад ХБИ-ийн дэд бүтцийг байгуулж өгөх шаардлагатай байна.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж байгаа дэд бүтцийн үйлчилгээг боловсронгуй болгох зөвлөмж**

Судалгааны ажилд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай ойлголт, ХБИ-дэд зориулсан дэд бүтцийн үйлчилгээний өнөөгийн байдал хууль эрх зүйн орчин, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хандлага, туршлагыг судалснаар дараах зөвлөмжүүдийг гаргаж байна.

#### **Зөвлөмж:**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн стандартыг хэрэгжүүлэх ажлыг сайжруулах.

Үүнд: Үүний тулд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1. Хууль болон стандартын хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох төрийн байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх

2. ТББ-дын зүгээс ХБИ –дэд зориулсан бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар монитормыг хийх. Мониторыг судалгааны үр дүнг олон нийтэд болон шийдвэр гаргагчдад танилцуулах

3. МХЕГазраас шинээр баригдах гэж байгаа барилгуудын зураг төсөл гарахаас өмнө болон барилгын ашиглалтад ороход хяналт тавидаг байх

4. Холбогдох төрийн байгууллагын зүгээс Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд дараах байгууллагуудтай хамтран ажиллах. Тухайлбал: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд , тэдний эрх ашгийг хамгаалдаг төрийн бус байгууллагууд, ажил олгогчид аж ахуйн нэгж ,төрийн байгууллагууд экспертүүдийн санаа бодлыг нэгтгэн судалгаанд тулгуурлан бодлого гаргах

5. Холбогдох төрийн байгууллагын зүгээс дэд бүтцийн хөгжүүлэх ажилд иргэд аж ахуйн нэгжийг өргөнөөр оролцуулах

урамшуулалын олон аргыг бодлогын хэмжээнд тодорхойлох хэрэгжүүлэх. Дэд бүтэц тоног төхөөрөмжийг хяналтыг сайжруулах заалт нэмж өгөх .

Дэд бүтцийг хүртээмжтэй болгох чиглэлээр

1. Албан өрөө, дэлгүүр, зочид буудал болон төрийн байгууллагуудын байрыг налуу зам саадгүй өргөн хаалга, бие засах өрөө болон цахилгаан шатаар тоноглуулах талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх

2. Төрийн болон бизнесийн салбараас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамгийн ээлтэй буюу ороход тохиромжтой болгосон байгууллагуудыг шалгаруулан туршилтаас нь хуваалцах

#### **НОМ ЗҮЙ**

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт хүний эрхийн байр суурь УБ 2006 он

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн НҮБ конвенц 2008 он

3. Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он

4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль 1998 он

5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэгш боломж олгох стандарт дүрмүүд 1993 он

6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр УБ 2006 он

7. Хүн ам орон сууцны тооллого 2010 он

8. Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль БД 38-101- 04

9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль